



ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 19/01

Улаанбаатар хот

Үндэсний хорооны ажлын төлөвлөгөө батлах,
гишүүдэд чиглэл өгөх тухай

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 51 дүгээр захирамжаар батлагдсан "Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажиллах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд 2019 оны төсвийн 75 221 100 000 /далан таван тэрбум хоёр зуун хорин нэгэн сая нэг зуун мянган/ төгрөгт багтаан 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд 2019 онд гишүүдийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар баталсугай.
3. Арга хэмжээний тайланг улирал тутмын эхний 7 хоногийн Баасан гаригт Ажлын албанд хүргүүлэхийг үндэсний хорооны гишүүдэд даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Ч.Гантулгад даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА

Н.ЦЭРЭНБАТ

ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХАД 2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

АОБҮХ-т туснаар	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний заалт	Д/Д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Хугацаа/сар	Хариуцах /хамтрах газар	Хөрөнгө		Нэмэлт тайлбар
							Эх үүсвэр	Төсөв /сая төгрөг	
4.2.4, т2.4.1	Гэр хорооллын айл өрхийг шөнийн тарифын хөнгөлөлтөд хамруулах	1	Агаарын чанарыг сайжруулах бүсийн халаалтаа цахилгаанаар шийдсэн гэр хорооллын айл өрхөд шөнийн цахилгааны үнийн урамшуулал олгох	Шаардлага хангасан айл өрхөд шөнийн цахилгааны үнийн урамшуулал олгосон байна.	I-III, XI-XII	ОББҮХ, ЭХЯ	УТ	10,000	
4.2.7	Бага, дунд оврын халаалтын зууханд утаа шүүх фильтр суурилуулахад дэмжлэг үзүүлэх	2	Халаалтын зууханд суурилуулах утаа шүүх фильтр худалдан авах	1110 халаалтын зууханд утаа шүүх фильтр суурилуулсан байна.	II-VI	ЭХЯ, НЗДТГ	УТ	8,355	Төсвийн байгууллагад төсвийн зардлаар - 4,746,900,000.0, Айл өрх, хувийн хэвшилд ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлт татаас-5,253,100,000.0
		3	Халаалтын зууханд утаа шүүх фильтр суурилуулж, хаягдлыг бууруулах		VI-X			1,645	
4.2.3, т2.3.1	Сайжруулсан түлш үйлдвэрлэж түгээх, иргэд худалдан авахад дэмжлэг үзүүлэх	4	Шаардлага хангасан сайжруулсан түлшний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх	Тавантолгой түлш компанийн түлш үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлж нөөц бүрдүүлсэн байна. /450'000тн-оос багагүй/ Хувийн хэвшлийн түлш үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлж нөөц бүрдүүлсэн байна. /150'000тн/	III-X	БОАЖЯ, ЭХЯ, НЗДТГ	УТ	10,000	
					III-X			8,000	
		5	Сайжруулсан түлшний худалдан авалтад дэмжлэг үзүүлэх	"Сайн карт"-аар дамжуулан сайжруулсан түлш зээлээр түгээх схем ажиллуулж, зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаас олгоно.	III-XII	БОАЖЯ, НЗДТГ, Банк	УТ	9,790	Төрийн банк болон боломжит бусад арилжааны банкаар дамжуулан түлш зээлээр олгох схем ажиллуулах
т2.3.2	Сайжруулсан түлш нөөцлөх цэг, борлуулалтын сүлжээ байгуулахад дэмжлэг үзүүлэх	6	Сайжруулсан түлш нөөцлөх цэг, борлуулалтын сүлжээний үйл ажиллагааг дэмжих	Сайжруулсан түлшний түгээлт, борлуулалтын сүлжээний үйл ажиллагаа жигдэрсэн байна.	III-XII	НЗДТГ	УТ, ОТ	1,000	
4.2.11, 4.5.3, т5.3.1, 2.11.3	Гэр хорооллын нутаг дэвсгэрт агаарын бохирдлын хяналт, мониторинг, туршилт явуулах	7	Түүхий нүүрсийг хориглох, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэл, нийлүүлэлтэд хяналт тавих	4 түвшний 4604 хүнээс бүрдсэн хяналтын багийг 9 сарын хугацаанд ажиллуулж, хууль тогтоомжийн зөрчил гарахаас сэргийлнэ.	VIII-XII	НЗДТГ, НМХГ, ТББ	УТ, ОТ	3,000	
			Түүхий нүүрсийг хориглох шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд Улаанбаатар хот руу орх гол чиглэлийн замууд дээр хяналт тавихад дэмжлэг үзүүлэх	4 цэгт хяналтын пост ажиллуулж, түүхий нүүрсийг ахуйн хэрэгцээний зориулалтаар хот руу оруулахаас сэргийлнэ.	III-XII	МХЕГ, ЦЕГ, НЗДТГ	УТ	560	
		8	Сайжруулсан түлшний туршилт, чанарын хяналт, орчны бохирдлын хяналт шинжилгээ явуулах	Түлшний чанарын туршилт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, орчны бохирдлын хяналт шинжилгээний дүгнэлт, тайлан гарсан байна.	I-XII	БОАЖЯ, НЗДТГ	УТ	255	
		9	Түлш борлуулалтын цэгээр дамжуулан хаягдал дугуй, боловсруулах боломжтой бусад хаягдлыг худалдан авах, дахин боловсруулах төслийг дэмжих	Хаягдал шатаахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хаягдал бууруулах дахин боловсруулалтыг дэмжсэн байна.	II-X	ОББҮХ, НЗДТГ	УТ	600	
		10	Агаарын чанарыг сайжруулах бүсийн цэцэрлэгийн нам даралтын зуухыг цахилгаан бага хэрэглэдэг бойлуургаар солих	Агаарын чанарыг сайжруулах бүсийн 17 цэцэрлэгийн барилгын халаалтыг цахилгаан халаалтаар шинэчилж, түүхий нүүрс түлдэг эх үүсвэрийг бууруулна.	III-XI	БОАЖЯ, НЗДТГ	УТ	1,400	600-1200м2 талбайг халаах цахилгаан зуух суурилуулах зардал 67-80 сая төгрөг

	болон бусад үр ашигтай технологи ашиглан шийдэх	11	Сургууль, цэцэрлэгийн барилгын дулаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр шийдэх	СХД-ийн 122-р сургуулийн халаалтыг газрын гүний дулааны насос суурилуулж шийдсэн байна.	II-X	БОАЖЯ, НЗДТГ	УТ	720	СХД-ийн 122-р сургуулийн 3500 м2 барилга, ДДНХБ-ын хийсэн ТЗЗҮ-ээр 712 сая төгрөг
		12	Агаарын чанарыг сайжруулах бүсэд байрлах Улаанбаатар цаг уур, орчны шинжилгээний төвийн нам даралтын зуухыг цахилгаан бага хэрэглэдэг бойлуургаар солих	Хотын төвд түүхий нүүрс түлдэг 1 зуух хаагдана. Агаарын чанарын хяналтын УБ-3 харуулын дүн мэдээнд нөлөөлөл үзүүлэхгүй болно.	I-III	БОАЖЯ, ЦУОШГ	УТ	180	Агаарын чанарын хяналтын УБ-3 харуулын дүн мэдээнд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол зорилготой.
4.1.6, т1.6.4	Гэр хорооллын 20,602 айл өрхийг цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх	13	"Хүчит шонхор" дэд станцын барилга угсралтын талбайн шарилыг шилжүүлэх	Дэд станцын барилга угсралтын ажил явагдаж, техникийн нөхцөл бүрдсэн байна.	I-III	НЗДТГ	УТ, ОТ	1,400	
4.2, т1.10.1, 2.9.1	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих, урамшуулах	14	Гэр хорооллын ариунцэврийн байгууламж, цэвэрлэх байгууламжийн лаг хаягдлыг байгальд халгүй аргаар шатааж устгах туршилтын төсөл хэрэгжүүлэх	Зориулалтын тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, хаягдлыг хал багатай аргаар устгах хөрс хамгааллын жишиг туршилтын төсөл хэрэгжсэн байна.	II-X	БОАЖЯ	УТ	3,500	
		15	Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах дэвшилтэт техник технологийн судалгаа хийж, тоног төхөөрөмжийн технологийн үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах	Байгальд ээлтэй, байгалийн нөөцийг хэмнэлттэй техник технологийн судалгаа, шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна.	II-V	БОАЖЯ	УТ	20	
		16	Агаар, орчны бохирдлыг бууруулах дэвшилтэт техник, технологийг туршин нэвтрүүлэх	Агаар, орчны бохирдлыг бууруулах байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг туршсан байна.	III-X	БОАЖЯ	УТ	3,000	
		17	Богдхан уулын Зайсангийн аманд нийтийн эко ариун цэврийн байгууламж барих	Орчны бохирдол буурах, иргэд цэвэр агаарт явган аялалд гарах нөхцөл бүрдэнэ.	II-X	БОАЖЯ, НЗДТГ	УТ	170.1	
		18	Эх үүсвэр дээр нь ангилан ялгасан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх туршилтын систем ажиглуулах	ЗР-ын зарчмыг хэрэгжүүлэх системийг туршсан байна.	II-X	БОАЖЯ, НЗДТГ	УТ	500	
		19	Орон нутагт хаягдал хуванцар сав жижиглэж бутлах төхөөрөмж суурилуулж хог хаягдлын зохистой менежментийг дэмжих	6 аймагт туршилтын төсөл хэрэгжүүлсэн байна.	II-X	БОАЖЯ, АЗДТГ	УТ	150	
		20	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2018 оны 43-р тогтоолын 1.5-д заасны дагуу ногоон зээлийн бүтээгдэхүүн бий болгоход дэмжлэг үзүүлж, зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаас олгох	Цахилгаан халаагуур, дулаалгын материал, утаа шүүгч, эко ариунцэврийн байгууламж зэрэг бараа бүтээгдэхүүн худалдан авах хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн бий болгоно.	I-XII	БОАЖЯ, ТөС холбоо, банкууд	УТ	2,000	Банкуудаар дамжуулан иргэд, ААН-д олгох ногоон зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаас
4.2.17, т2.17.2	Ногоон зээлийн сангийн үйл ажиллагааны хүрээнд агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй ногоон төсөл, санаачилгыг дэмжих	21	Дулааны алдагдал бууруулах төсөл, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Дулааны алдагдлыг бууруулах ногоон зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаас олгосон байна.	I-XII		УТ	1,000	
		22	Олон нийт рүү чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах, мэдээллийн төв ажиглуулах	Олон нийтийн мэдлэг, хандлага, оролцоо сайжирсан байна.	I-XII	БОАЖЯ, НЗДТГ, ТББ	УТ, ОТ	560	Сайжруулсан түлш, дулаалга, цэвэр технологи, эко ариунцэврийн байгууламж, хог хаягдал зэрэг сэдвээр
4.5.1, т5.1.1, 5.2.1, 2.16.1	Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр олон нийт рүү чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгаа	23	Гарын авлага, сурталчилгааны болон холбогдох материал хэвлүүлэх	Сургалт сурталчилгаа, тараах материал, хяналтын хуудас, падан зэргийг хэвлэж ашигласан байна.	I-XII	ОББҮХ	УТ	250	
4.5.9, т5.9.1	Томоохон хотууд, аймгийн төв сууринг PM10, PM2.5 тоосонцор хэмжих автомат багажаар тоноглох, хяналт-шинжилгээний сүлжээг бэхжүүлэх, туршилт судалгаа хийх	24	3 аймгийн төвд агаарын бохирдлыг хянах харуулын байр суурилуулж, PM10/PM2.5 тоосонцор хэмжих автомат багажаар тоноглох, хяналт-шинжилгээний сүлжээг бэхжүүлэх, туршилт судалгаа хийх	Агаарын чанарын хяналт шинжилгээний сүлжээний нэгдмэл, тасралтгүй ажиллагаа хангагдана.	III-X	ОББҮХ, БОАЖЯ	УТ	350	1. PM10/2.5 хэмжих бага үнэтэй сенсоруыг турших, 2. Цэцэрлэг, Өлгий, Улаангом хотыг PM10/2.5 тасралтгүй хэмжих багажаар тоноглох, бусад туршилт
		25	Хяналтын зөөврийн багаж төхөөрөмжийн судалгаа хийж худалдан авах	Хяналтын зөөврийн багаж төхөөрөмжөөр хяналтын хэмжилт хийдэг болно.	III-X	ОББҮХ, БОАЖЯ	УТ	120	

4.5.10, т5.10.1	Бохирдлын эх үүсвэрийн цахим мэдээллийн технологийг хөгжүүлэх	26	Бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллого явуулж цахим бүртгэл мэдээллийн системийг боловсронгуй болгох	Газарзүйн мэдээллийн системд суурилсан бохирдлын суурин эх үүсвэрийн бүртгэл мэдээллийн цахим сан бүрдсэн байна.	III-XII	БОАЖЯ, НЗДТГ	УТ	400	
4.4.3, т5.9.4	Агаарын бохирдол ихтэй аймгуудад дэмжлэг үзүүлэх	27	Аймгийн төвүүдийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	Үр дүн сайтай арга хэмжээг санхүүжүүлэх дэмжлэг олгосон байна.	III-XII	БОАЖЯ, АЗДТГ	УТ, ОТ	2,000	
		28	Ховд аймгийн төвийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ	Аймгийн төвийн агаарын бохирдлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авсан байна.	III-XII	АЗДТГ	УТ	800	
4.5.5, т5.5.3	Хүн амыг агаар, орчны бохирдлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх хамгааллын арга хэмжээ авах	29	Эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг вакцинжуулалтад хамруулах	Эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг дархлаажуулахад шаардагдах 56110 хүн/тун вакцин худалдан авч, 56110 хүнийг хамруулсан байна.	VIII-XII	ЭМЯ	УТ	524	
4.3.4, т3.3.3	Нийтийн тээврийн автобуснаас ялгарах утаа, тортогийг бууруулах арга хэмжээ авах	30	Насжилт багатай нийтийн тээврийн автобусанд DPF шүүлтүүр авч суурилуулах	Автобусанд DPF шүүлтүүр авч суурилуулсан байна.	II-X	ЗТХЯ, НЗДТГ	УТ	2,750	
	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны үйл ажиллагааны зардал	31	Үндэсний хороо, Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг хангах	Үндэсний хороо, Ажлын албаны тасралтгүй ажиллагаа хангагдана.	I-III	ОББҮХ	УТ	222	
Нийт								75,221.1	

ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖЛЫН АЛБА